

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	9
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ТХН	Төсөл хэрэгжүүлэгч нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨР 4, 4
НЭМЭЛТ, ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ А.МӨНХТАЙВАН
ТАНАА

2020.05.01 № 06/1478
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч А.Мөнхтайван Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасаншийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн заавар, аргачлалд нийцсэн санхүүгийн программ хангамж ашиглах, Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 25-наас 2020 оны 04 дүгээр сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван Аудит ХХК-ийн захирал Ц.Жигдэн хянан удирдаж, чанарын хяналтын менежер М.Болормаа, аудитор Ц.Ганболд, Ц.Бямбасүрэн нар хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 15 дугаар бүхий албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Далайван Аудит ХХК нь 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 59 тоот албан бичгээр төслийн нэгжийн санхүүгийн тайланг хүлээн авч аудитын ажлыг эхлүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 нэмэлт санхүүжилт төсөл: Төслийн зорилго: Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн дэргэд 50 ортой өргөтгөл барих байсныг өөрчлөн Улсын Их хурлаар 2011 онд батлагдсан “Эрүүл мэндийн тухай” хуулийн нэмэлт өөрчлөлтөөр дүүргийн эмнэлгийг 7 ба түүнээс дээш төрөлжсөн мэргэшлийн тусламж үзүүлдэг эмнэлэг байхаар тусгагдсаны дагуу тус дүүрэгт зээлийн нэмэлт санхүүжилтээр 200 ортой, мэс засал, эх барих, эмэгтэйчүүд, гэмтэл, дотор, хүүхэд, хавдрын тусламж үйлчилгээг үзүүлэх жишиг нэгдсэн эмнэлгийг барих, ажиллагаанд оруулах зорилготой.

Азийн хөгжлийн банк, Монгол Улсын Засгийн газрын хооронд 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4 төсөл, нэмэлт санхүүжилт”-ийг хэрэгжүүлэх зээлийн хэлэлцээрийг баталсан. Хэлэлцээрт 16,240,000 Зээлжих тусгай эрх буюу 25,000,000 ам.доллартой тэнцэхүйц зээлийг олгохоор болсон. Төслийн хаалтын хугацаа 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болно.

Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдөр олон улсын тендерт шалгарсан Австри улсын Вамед Инженеринг компанитай Сонгинохайрхан дүүрэгт эмнэлгийн барилга угсралт, тоног төхөөрөмж нийлүүлэх ажил гүйцэтгүүлэх (24,800,000 ам.доллар) гэрээг байгуулан ажиллаж байна.

Барилга угсралтын ажил 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 90.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Шинээр батлагдсан стандарт дүрэм журмыг мөрдөх, эмнэлгийн барилгын шинэ технологитой холбоотой болон барилга угсралтын ажлын гүйцэтгэлд ажлын тоо, хэмжээний өөрчлөлт гарсантай холбоотой барилгын ажлыг дуусгахад дутагдаж буй санхүүжилтийг АХБ-ны Захирлуудын зөвлөлийн хурлаар энэхүү нэмэлт санхүүжилтийн зээлийн 16,000,000 ам.долларыг 2019 оны 6 сард баталж, нэмэлт санхүүжилтийн зээлийн гэрээг 2019 оны 10 дугаар сард УИХ-ын хуралдаанаар баталсан.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 төсөл: Төслийн зорилго нь эрүүл мэндийн салбарын үр өгөөж, засаглал, мөн эмийн аюулгүй байдлыг сайжруулахад оршино.

Азийн Хөгжлийн Банк (АХБ) болон Монгол Улсын Засгийн газрын хооронд 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан буцалтгүй тусламжийн хэлэлцээрээр “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4 төсөл”-ийг хэрэгжүүлэхэд Азийн хөгжлийн банкны тусгай сангийн нөөцөөс 14,000,000 ам.доллартой тэнцэхүйц буцалтгүй тусламж, Монгол Улсын Засгийн газраас 3,700,000 ам.долларын санхүүжилт, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 450,000 ам.долларын мөнгөн бус санхүүжилт олгохоор болсон. АХБ-наас 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдөр төслийн дуусах хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан.

Улаанбаатар хотын эмнэлгийн тусламж, үйлчилгээг бэхжүүлэх ажлын хүрээнд эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэл мэдээллийн программ хангамж болон Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээний сангийн журмыг ЭМЯ-ны Цахим удирдах хорооны 2019 оны 4 дүгээр сарын 20 өдрийн хурлаар хүлээн авсан байна.

Хүний нөөцийг хөгжүүлэх ажлын хүрээнд резидентийн дотор, эх барих эмэгтэйчүүд, мэс засал, хүүхдийн өвчин судлалын үндсэн 4 мэргэшлээр Сонгинохайрхан дүүргийн эмнэлэгт ажиллах 29 их эмчийг болон 11 чиглэлийн нарийн мэргэжлийн сургалтанд 15 сувилагчийг тус тус сургасан. Нэмэлтээр 6 их эмч урологи, зүрх судас, гастроэнтерологи, диализ, геронтологийн төрөлжсөн нарийн мэргэжлийн сургалтанд суралцаж байна. Мөн дотор, эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн өвчний сурах бичгийг нэмэлтээр 2019 онд дахин

800 хувь хэвлүүлж, ЭМЯ-ны баталсан хуваарийн дагуу эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад тараасан.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төсөл нь 2018 онд санхүүгийн тайлангаа Эрүүл мэндийн яаманд өгч улсын төсөвт нэгтгүүлсэн.

Улсын Их Хурлаас Монгол Улсын 2019 оны жилийн төсвийг боловсруулахдаа Засгийн газрын шугамаар хэрэгжиж байгаа зээл, тусламжийн бүх төсөл хөтөлбөрүүд Сангийн сайдын багцад шилжүүлэн баталсан. Үүнтэй холбоотойгоор төсөл нь 2018 оны 12 сарын 31-нээр тасалбар болгосон хаалтын тайлангаа өгч Сангийн яаманд балансын тэг үлдэгдэлтэй шилжсэн.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Засгийн газрын 2016 оны 176 тоот тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах, журам”
- Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бүрэлдэхүүн болох Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”
- Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”.

Тайлант хугацаанд төслийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төслийн үндсэн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашигладаггүй, хэрэглээний “Microsoft Excel” ашиглан нягтлан бодох бүртгэл хөтөлдөг байна.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Төсөл нь төлөвлөсөн үйл ажиллагааг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх, зээлийн хөрөнгийг зорилгын хүрээнд үр ашигтай зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, ил тод байдлыг хангахын тулд төслийн гүйцэтгэлийн хяналт, санхүүгийн хяналт, худалдан авах үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлдэг. АХБ болон төслийн гүйцэтгэгч байгууллагаас төслийн үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж ажилладаг.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төслийн үйл ажиллагаанд зориулсан төлбөрүүдийг төлөхдөө гүйцэтгэгч болон АХБ-наас хяналт хийгэж зөвшөөрөгдсөн зардлуудыг санхүүжүүлдэг тул санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн дүнгээс тооцох нь илүү бодитой гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 52,765,383.6 мянган төгрөгөөс 1,055,307.8 мянган төгрөгөөр тооцон материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,038,157.1 мянган төгрөгөөр буюу 117.97 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, дуусаагүй барилга, богино хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүн данс байна.

Хүснэгт 1. Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,265,268.5	769,834.4	(495,434.1)
Урьдчилж гарсан зардал	6,091,979.1	945,501.8	(5,146,477.3)
Үндсэн хөрөнгө	167,727.2	167,727.2	-
Хуримтлагдсан элэгдэл	(160,512.3)	(162,784.2)	(2,271.9)
Дуусаагүй барилга	37,362,763.9	51,050,174.3	13,687,410.4
Нийт хөрөнгө	44,727,226.5	52,770,453.5	8,043,227.0
Богино хугацаат өр төлбөр	1,896,840.3	5,130,929.8	3,234,089.5)
Урьдчилж орсон орлого	1,130,807.1	645,164.8	(485,642.3)
Засгийн газрын оруулсан капитал	-	-	-
Хуримтлагдсан үр дүн	41,699,579.0	46,994,358.9	5,294,779.9
Өмнөх оны үр дүн	14,321,980.2	41,699,579.0	27,377,598.8
Тайлант оны үр дүн	27,377,598.9	5,294,779.9	(22,082,819.0)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	44,727,226.5	52,770,453.5	8,043,227.0

Мөнгөн хөрөнгө:Төсөл нь тайлант хугацааны эцэст ам.долларын дансны үлдэгдэл 592,318.4мянган төгрөг, төгрөгийн дансдын 177,516.0 мянган төгрөг нийт үлдэгдэл 769,834.4 мянган төгрөг тайлагнасан байна.

Урьдчилж гарсан зардал:Тоног төхөөрөмж ханган нийлүүлж, суурилуулах ажлын 10 хувийн урьдчилгаа 400,318.33 ам.доллар буюу 940,431.8 мянган төгрөг, олон нийтийн онооны картын аргаар эмнэлгийн үйлчилгээнд үнэлгээ хийх аргазүйн гарын авлагыг боловсруулах ажлын төлбөр 5,070.0 мянган төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад төлж урьдчилж гарсан зардлаар тайлагнасан.

Үндсэн хөрөнгө:Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр төслийн нэгжийн үйл ажиллагаанд зориулан худалдан авсан тээврийн хэрэгсэл, компьютер, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөөрбүртгэсэн. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөд 2,271.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардлаар бүртгэсэн.

Дуусаагүй барилга:Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлэг барих, эмнэлгийн тоног төхөөрөмж суурилуулах ажлын зардал нийт 51,050,174.3 мянган төгрөгийг дуусаагүй барилга дансанд хуримтлуулан бүртгэж тайлагнасан.

Богино хугацаат өр төлбөр:Сонгинохайрхан дүүргийн жишиг нэгдсэн эмнэлэг барих, эмнэлгийн тоног төхөөрөмж суурилуулах ажлын гүйцэтгэгч компаниас ирүүлсэн ажлын гүйцэтгэлүүдээс гэрээний дагуу төлөх 2,609,258.7 мянган төгрөг, барьцаа төлбөр 2,432,070.7 мянган төгрөг, нормчлолын сангийн төлбөр 84,949.9 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 919.7 мянган төгрөг, зөвлөхөд төлөх 3,690.3 мянган төгрөг,бичиг хэргийн зардлын өглөг 40.5 мянган төгрөгийг тус тус суутган тооцож өр төлбөрөөр тайлагнасан.

Урьдчилж орсон орлого: АХБ-наас төслийн үйл ажиллагаанд зарцуулахаар урьдчилан хүлээн авсан санхүүжилтийг урьдчилж орсон орлогоор тайлагнасан.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгон, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхэд зориулан тайлант онд 7,757,414.7

мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 5,578,802.4 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан.

Төсвийн зардлын гүйцэтгэл 6,110,559.6 мянган төгрөг буюу 78.8 хувьтай буюу төслийн нэгжийн үйл ажиллагааны зардал 1,646,855.1 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 2. Төсвийн орлого

/мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	6,178,419.0	5,505,705.3	(672,713.7)	89.1
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	1,398,795.7	-	(1,398,795.7)	100.0
Улсын төсвөөс санхүүжих	180,200.0	73,097.1	(107,102.9)	40.6
Нийт дүн	7,757,414.7	5,578,802.4	(2,178,612.3)	71.9

Хүснэгт 3. Төсвийн зардал

/ мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Урсгал зардал	1,519,414.7	739,111.4	780,303.3	48.6
Хөрөнгийн зардал	6,238,000.0	5,371,448.2	866,551.8	86.1
Нийт дүн	7,757,414.7	6,110,559.6	1,646,855.1	78.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан төсвийн хүрээнд зүй зохистой зарцуулсан.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 3горим сорилхэрэгжүүллээ.

Аудитаар нийт 8,760.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 8,760.3 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад санхүүгийн тайланд дараах залруулгыг хийв. Үүнд:

- Олон нийтийн онооны картын аргаар эмнэлгийн үйлчилгээнд үнэлгээ хийх аргазүйн гарын авлагыг боловсруулах ажлын урьдчилгаа төлбөр 5,070.0 мянган төгрөгийг тайлант хугацааны зардлаар бүртгэсэн, мөн зөвлөх үйлчилгээний төлбөрийн үлдэгдэл 1,350 ам.доллар буюу 3,690.3 мянган төгрөгөөр өр төлбөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ийн 2.1.3-т төсвийн байгууллага нь санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккрузэл суурь дээр үндэслэн бэлтгэнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дор дурдсан асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Төслийн хаалтын хугацаа 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр тул төслийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтийг хянах;
- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд шаардсан мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг хянах;

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө болон төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг эдийн засгийн ангиллаар нь задалж тайлагнаж байгаа эсэхийг хянах;
- Төсвийн тухай хуульд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага тул нягтлан бодох бүртгэлээ УСНББОУС-ын дагуу бүрэн аккруэл сууриар бүртгэхтэй холботойгоор олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдсэн заавар, аргачлалыг Сангийн Яамнаас тусгайлан гаргах хэрэгтэй байна. Уг заавар, аргачлалд төслийн нэгж нь АХБ-ны зарцуулалтын үндсэн процедур болох шууд төлбөр, урьдчилгаа төлбөр, нөхөн дүүргэлтийг аккруэль сууриар хэрхэн хүлээн зөвшөөрч бүртгэж, тайлагнах, хүлээн авсан болон зарцуулсан санхүүжилтэнд гадаад валютын ханшийг хэрхэн ашиглах, төслийн санхүүжилтээр бий болсон биет болон биет бус хөрөнгийг элэгдүүлэх хугацаа болон арга, төслийн санхүүжилтээр баригдаж байгаа барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг хэрхэн хуримтлуулан бүртгэх, хөрөнгийг төсөл дуусахад төрийн өмчид шилжүүлэх, зээл тусламжийг төслийн нягтлан бодох бүртгэлд өр төлбөрөөр тусгах эсэх, зээлийн хүүгийн өр төлбөрийг хэрхэн бүртгэх;
- Худалдан авах ажиллагаа болон төслийн үйл ажиллагааг санхүүжүүлэх процесс нь Азийн Хөгжлийн Банк, Монгол Улсын Засгийн газрын хооронд 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан гэрээ болон Олон улсын гэрээ хэлцэл, дүрэм журмыг баримталдаг тул мөрдөж ажилласан эсэхийг анхаарх;
- Тайлант оны сүүлээр зарласан Эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлын тендерүүдийг нээж дуусаагүй, үнэлгээ хийх процесс нь он дамнаж байгаа тул хяналт хийх, төслийн хаалтын хугацаа 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр тул гэрээний хэрэгжилтийн байдалд дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 147 мэдээллийг оруулахаас 129 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр өмч/өмчийн өөрчлөлтболон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн программ хангамжийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд нь оффисын хэрэглээний “Майкрософт эксэль” ашиглан бүртгэл хөтлөж байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, УСНББОУС-д нийцээгүй, харин АХБ-ны Зарцуулалтын журмын дагуу мөнгөн сууриар нягтлан бодох бүртгэл хөтлөхөөр тохируулга хийгдсэн байна.

Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төслийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал буруу, алдаатай бэлтгэгдэх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн хууль УСНББОУС-ын шаардлагад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн программ хангамжтай болох.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

АХБ болон Төсвийн байгууллагын санхүүгийн тайланг зэрэг бэлтгэдэг санхүүгийн программ одоогоор байхгүй тул нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг хэрэглээний “Майкрософт эксэль” ашиглан нягтлан бодох бүртгэл хөтлөж байгаа болно.

3.2 Шилэн дансны мэдээллийн талаар

3.2.1 Илрүүлэлт:

Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 147 мэдээллийг оруулахаас 129 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

3.2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хууль зөрчих, мэдээлэл буруу орох,

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг тогтсон хугацаанд нь бүрэн гүйцэт оруулах.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	7,357,247,669.33	1,715,336,259.72
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,265,268,549.83	769,834,435.70
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,265,268,549.83	769,834,435.70
31210	Төгрөг	120,698,445.41	177,516,078.12
31211	Төрийн сангийн харилцах	119,370,769.60	166,359,169.97
31213	Арилжааны банк дахь харилцах	1,327,675.81	11,156,908.15
31220	Гадаад валют	1,144,570,104.42	592,318,357.58
31223	Арилжааны банк дахь харилцах	1,144,570,104.42	592,318,357.58
34	УРЬДЧИЛГАА	6,091,979,119.50	945,501,824.02
34600	Урьдчилж гарсан задал		5,070,000.00
34710	Урьдчилгаа тооцоо	6,091,979,119.50	940,431,824.02
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	6,091,979,119.50	940,431,824.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	37,369,978,820.74	51,055,117,329.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	37,369,978,820.74	51,055,117,329.90
39200	Биет хөрөнгө	37,369,978,820.74	51,055,117,329.90
39203	Авто-тээврийн хэрэгсэл	64,341,432.00	64,341,432.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(64,341,432.00)	(64,341,432.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	79,653,056.51	79,653,056.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	(75,365,275.04)	(76,520,802.22)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,732,725.78	23,732,725.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,805,631.45)	(21,921,939.68)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	37,362,763,944.94	51,050,174,289.51
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	44,727,226,490.07	52,770,453,589.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,027,647,456.89	5,776,094,675.82
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,027,647,456.89	5,776,094,675.82
41300	Өглөг	1,896,840,307.97	5,130,929,833.49
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1,896,840,307.97	2,517,020,647.72
41360	Бусад өглөг	-	2,613,909,185.77
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,613,909,185.77
41400	Урьдчилж орсон орлого	1,130,807,148.92	645,164,842.33
41440	Бусад урьдчилж орсон орлого	1,130,807,148.92	645,164,842.33
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	41,699,579,033.18	46,994,358,913.80
51	Засгийн газрын хувь оролцоо	41,699,579,033.18	46,994,358,913.80
51200	Хуримтлагдсан үр дүн	41,699,579,033.18	46,994,358,913.80
51210	Өмнөх үеийн үр дүн	14,321,980,179.05	41,699,579,033.17
51220	Тайлант үеийн үр дүн	27,377,598,854.13	5,294,779,880.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	44,727,226,490.07	52,770,453,589.62

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	28,571,736,477.45	6,203,875,197.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	28,539,096,477.45	6,023,675,197.32
120	Нийтлэг татварын бус орлого	28,422,405,734.50	5,688,198,792.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,422,405,734.50	5,674,135,765.63
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,296,289.31	18,264,586.15
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	28,400,109,445.19	5,655,871,179.48
120009	Бусад орлого	-	14,063,026.37
122	Тусламжийн орлого	116,690,742.95	335,476,405.32
122002	Хандив тусламж /гадаад/	116,690,742.95	335,476,405.32
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,640,000.00	180,200,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	32,640,000.00	180,200,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	32,640,000.00	180,200,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,140,965,241.92	870,564,992.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,140,965,241.92	870,564,992.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,081,358,781.92	745,171,392.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	273,990,600.00	-
210101	Үндсэн цалин	273,990,600.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,543,520.00	16,513,623.00
210201	Тэтгэврийн даатгал	32,543,520.00	16,513,623.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,400,735.30	4,171,822.85
210401	Бичиг хэрэг	3,391,576.72	776,954.55
210402	Тээвэр, шатахуун	1,761,545.18	2,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,247,613.40	994,868.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	548,257,522.12	198,863,776.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	548,257,522.12	198,863,776.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	219,166,404.50	525,622,169.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	213,666,897.73	523,350,334.46
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,499,506.77	2,271,835.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,606,460.00	125,393,599.52
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,606,460.00	125,393,599.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,606,460.00	107,102,927.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	18,290,672.52
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	27,430,771,235.53	5,333,310,205.11
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	27,252,896.62
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	27,252,896.62
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	53,172,381.39	65,783,221.10
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	53,172,381.39	65,783,221.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	27,377,598,854.14	5,294,779,880.63

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	29,389,163,988.11	1,612,053,259.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,356,523,988.11	1,431,853,259.80
120	Нийтлэг татварын бус орлого	29,356,523,988.11	1,431,853,259.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,524,814,043.19	1,417,790,233.43
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	22,296,289.31	18,264,586.15
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	28,502,517,753.88	134,257,097.45
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	-	1,265,268,549.83
120009	Бусад орлого	-	14,063,026.37
122	Тусламжийн орлого	831,709,944.92	-
122002	Хандив тусламж /Гадаад/	831,709,944.92	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,640,000.00	180,200,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	32,640,000.00	180,200,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	32,640,000.00	180,200,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,283,907,950.83	868,712,689.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,283,907,950.83	868,712,689.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,224,301,490.83	743,319,089.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,543,520.00	16,513,623.00
210201	Тэтгэврийн даатгал	32,543,520.00	16,513,623.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,400,735.30	4,171,822.85
210401	Бичиг хэрэг	3,391,576.72	776,954.55
210402	Тээвэр, шатахуун	1,761,545.18	2,400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,247,613.40	994,868.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	961,249,466.15	197,903,561.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	961,249,466.15	197,903,561.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	223,107,769.38	524,730,082.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	223,107,769.38	524,730,082.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,606,460.00	125,393,599.52
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	59,606,460.00	125,393,599.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,606,460.00	107,102,927.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	18,290,672.52
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	28,105,256,037.28	743,340,570.31
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	27,978,532,291.69	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27,978,532,291.69	-
2200	Дотоод эх үүсвэрээр	27,978,532,291.69	-
220001	Барилга байгууламж	27,978,532,291.69	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(27,978,532,291.69)	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(8,834,909.83)	26,493,865.39
14	Бусад эх үүсвэр	-	27,252,896.61
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	27,252,896.61
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	8,834,909.83	759,031.22
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	8,834,909.83	759,031.22
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	117,888,835.76	769,834,435.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,147,379,714.07	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,265,268,549.83	769,834,435.70

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,160,094,096.64	1,160,094,096.64
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	13,161,886,082.41	13,161,886,082.41
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	14,321,980,179.05	14,321,980,179.05
9	Тайлант үеийн үр дүн	-	-	27,377,598,854.13	27,377,598,854.13
10	2018 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	41,699,579,033.18	41,699,579,033.18
11	2019 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	41,699,579,033.18	41,699,579,033.18
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	41,699,579,033.17	41,699,579,033.17
19	Тайлант үеийн үр дүн	-	-	5,294,779,880.63	5,294,779,880.63
20	2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	46,994,358,913.80	46,994,358,913.80

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,757,414,700.00	6,110,559,563.07	1,646,855,136.93	78.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,519,414,700.00	739,111,382.31	780,303,317.69	48.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,519,414,700.00	739,111,382.31	780,303,317.69	48.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,300,000.00	16,513,623.00	3,786,377.00	81.35
210201	Тэтгэврийн даатгал	20,300,000.00	16,513,623.00	3,786,377.00	81.35
2104	Хангамж, бараа материалын зардал	8,319,100.00	4,171,822.85	4,147,277.15	50.15
210401	Бичиг хэрэг	3,455,200.00	776,954.55	2,678,245.45	22.49
210402	Тээвэр, шатахуун	2,961,600.00	2,400,000.00	561,600.00	81.04
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,902,300.00	994,868.30	907,431.70	52.30
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,191,600.00	193,695,854.00	106,495,746.00	64.52
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,191,600.00	193,695,854.00	106,495,746.00	64.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,190,604,000.00	524,730,082.46	665,873,917.54	44.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,190,604,000.00	524,730,082.46	665,873,917.54	44.07
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,238,000,000.00	5,371,448,180.76	866,551,819.24	86.11
220001	Барилга байгууламж	5,420,000,000.00	5,371,448,180.76	48,551,819.24	99.10
222001	Тоног төхөөрөмж	818,000,000.00	-	818,000,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,757,414,700.00	5,578,802,351.21	2,178,612,348.79	71.92
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	180,200,000.00	73,097,073.00	107,102,927.00	40.56
310001	Улсын төсвөөс санхүүжих	180,200,000.00	73,097,073.00	107,102,927.00	40.56
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,178,419,000.00	5,505,705,278.21	672,713,721.79	89.11
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	6,178,419,000.00	5,505,705,278.21	672,713,721.79	89.11
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,398,795,700.00	-	1,398,795,700.00	0.00
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	1,398,795,700.00	-	1,398,795,700.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	743,340,570.31	-743,340,570.31	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	-	-	-
650010	Гэрээт ажилтан	3	3	-	-

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020.04.27			САГ-2020/727/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төсөл		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр 4, 4 нэмэлт төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн програм хангамж ашигладаггүй, хэрэглээний “Microsoft Excel” ашиглан нягтлан бодох бүртгэлийг хөтөлдөг байна. Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, УСНББОУС-днийцэхгүй байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	А.Мөнхтайван
2	Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 147 мэдээллийг оруулахаас 129 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	А.Мөнхтайван
	Алдаа, зөрчлийн дүн	-			

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing a conclusion.